



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР  
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 08 сарын 03 өдөр

Дугаар 105

Хэрлэн сум

Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хууль тогтоомжийн мэдээлэл, системчлэл, дотоод  
ажил хариуцсан мэргэжилтний сул орон тоонд  
томилуулахаар нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.7, 3.5, 3.5.4 дэх заалт, 2023 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 12.1, 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалтад /67/ оноо авч, тэнцсэн Мөнхчулууны Шаравгавааг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомжийн мэдээлэл, системчлэл, дотоод ажил хариуцсан мэргэжилтний сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч М.Шаравгавааг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг 30 хоногийн дотор гаргаж, албан бичгээр ирүүлэх шаардлагатайг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолыг аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ТАНБААТАР